
**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн хугацаа: 2020 оны 10 сарын 20-ноос 2021 оны 1 сарын 25

Тайлан боловсруулсан:

Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ-ын тэргүүн	С.Энэбиш
Саран ээж нийгэмлэгийн аймгийн салбар зөвлөлийн тэргүүн	Г.Сэлэнгэ
Тунамал сэлэнгэ ТББ-ын тэргүүн	Д. Мядагсүрэн
Говийн хөгжлийн түшиг ТББ-ын гүйцэтгэх захирал	М.Ууганцэцэг
Өмнөговь Эмэгтэйчүүдийн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал	Б.Цэрэнлхам

2021 он

АГУУЛГА

- Товчилсон үгийн жагсаалт
- Хүснэгтийн жагсаалт
- Зургийн жагсаалт
- Талархал
- ОХШҮ-ний хураангуй
- 1. Удиртгал
 - 1.1 Үндэслэл
 - 1.2 Зорилго, зорилтууд
 - 1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ
- 2. ОХШҮ-ний арга зүй
 - 2.1 Мэдээлэл цуглуулах аргууд
 - 2.2 Түүвэрлэлт
 - 2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа
 - 2.4 Зөвлөлдөх уулзалтууд
- 3. ОХШҮ-ний үр дүн
 - 3.1 Оролцооны хяналт шинжилгээний үр дүн
 - 3.2 Оролцооны үнэлгээний үр дүн
 - 3.2.1 Ауулга
 - 3.2.2 Ганцаарчилсан ярилцлага
 - 3.2.3 Бүлгийн ярилцлага
- 4. Дүгнэлт
- 5. Бодлогын зөвлөмж
- 6. Ашигласан материал
- 7. Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт:

ОНЖДХ	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
ЖЭТБ	Жендэрийн эрх тэгш байдал
АЗДТГ	Аймгийн Засаг Даргын Тамгын Газар
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОХШҮ	Оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ
ОШҮ	Оролцооны шинжилгээ үнэлгээ
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ОНМХ	Олон нийтийн мэдээлэл харилцаа
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ТАХ	Төрийн албан хаагч
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ААН	Аж ахуйн нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Хүснэгтийн жагсаалт:

Хүснэгт-1: Баримт бичгийн жагсаалт

Хүснэгт-2: Мэдээлэлт цуглуулалтын түүвэрлэлт

Хүснэгт-3: Мэдээлэл цуглуулалтын ажлын төлөвлөгөө

Хүснэгт-4: ОНЖДХ-ийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл

Хүснэгт-5: ОНЖДХ-т хамаарах төлөвлөгдөөгүй хэрэгжсэн үйл ажиллагааны оролцогчид

Хүснэгт-6: Төлөвлөгдөөд хэрэгжээгүй ажлууд

Хүснэгт-7: ОНЖДХ-ийн төсвийн үзүүлэлтийн график

Хүснэгт-8: ОНЖДХ-ийн хүрээнд санхүүжигдсэн болон санхүүжигдээгүй үйл ажиллагаа

Хүснэгт-9: Шалгуур үзүүлэлтийн байдал

Хүснэгт-10: ОНЖДХ-ийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл

Хүснэгт-11: Асуулгын үр дүнгийн үзүүлэлт

Хүснэгт-12: Асуулгын үр дүнгийн үзүүлэлт

Хүснэгт-13: Дүгнэлт, бодлогын зөвлөмж

Зургийн жагсаалт:

Зураг-1: Цахим зөвлөлдөх уулзалт

Зураг-2: Цахим зөвлөлдөх уулзалт явц

Зураг-3: Цогт-овоо сумын зөвлөлдөх уулзалт

ТАЛАРХАЛ

Монгол Улсын Засгийн Газар, Жендэрийн Үндэсний Хорооноос Азийн Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлж буй “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техник туслалцааны төслийн хүрээнд орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд хамтран орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг хийх ажлыг аргачлалын дагуу гүйцэтгэн ажиллалаа.

Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан төслийг амжилттай хэрэгжүүлэх ИНБ-ын чадавхыг бэхжүүлэхэд дэмжин ажилласан Жендэрийн Үндэсний Хороо, санхүүжүүлэгч Азийн Хөгжлийн Банк, “Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ”-г хийх аргачлалыг боловсруулсан зөвлөх багийнхан, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг хийхэд өдөр тутам тусалж, үнэтэй зөвлөгөө өгч дэмжин ажилласан зөвлөх МУБИС-ийн багш, төслийн багийн ахлагч доктор, дэд проф С.Түмэндэлгэр, Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал, МУИС-ийн социологи, нийгмийн ажлын тэнхимийн докторант Ц.Одгэрэл, МУБИС-ийн социологи нийгмийн ажлын тэнхимийн багш, доктор проф Т.Бүрэнжаргал та бүхэнд талархал илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүсье.

Мөн баримт бичгийн шинжилгээ болон ганцаарчилсан ярилцлагад оролцож, мэдээ мэдээллээр хангаж дэмжин ажилласан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний ажлын алба, Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, бүлгийн ярилцлага болон зөвлөх уулзалтуудыг зохион байгуулахад дэмжиж хамтран ажилласан Ханхонгор, Цогт-овоо, Баяндалай сумдын Засаг дарга Б.Батбаатар, Н.Наранзаяа, У.Буян-өлзий болон асуумж судалгаанд идэвхтэй оролцон мэдээлэл өгсөн нийт, иргэд олон нийтэд төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сурталчилгааг хийхэд хамтран ажилласан орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууддаа талархал илэрхийлье.

ОХШҮ-НИЙ ХУРААНГУЙ

Өмнөговь аймгийн ИНБ-уудаас бүрдсэн ОХШҮ-ний баг 2020 оны 10 сараас эхлэн 2021 оны 01 сарын 25 хүртэлх хугацаанд ажиллаж, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн төлөвлөлт, үйл ажиллагааны үр дүн өгөөж, цаашид засч сайжруулах асуудлыг тодорхойлохоор оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг аргачлалын дагуу гүйцэтгэж ажиллалаа.

ОНЖДХ-өөр дэвшүүлсэн зорилго, зорилтууд ямар асуудал руу анхаарсан, дэвшүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн, оролцогчид, үр шим хүртэгчид нь хэн байсан, хэнд чиглүүлсэн, хэдий хугацаанд, ямар эх үүсвэрээс санхүүжүүлсэн, хэрэгжилтийг хэн хангаж ажилласан, хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийсэн, хэдий хугацаанд ямар, ямар үйл ажиллагааг төлөвлөсөн, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хэр үр дүнтэй байсан, цаашид засч сайжруулах асуудлын хүрээг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлж ажилласан.

ОНЖДХ-т оролцооны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аргачлалын дагуу гүйцэтгэж, орон нутгийн шийдвэр гаргагчидтай ярилцлага хийх, иргэдээс асуулга судалгаа авах, хөтөлбөрийн хүрээнд гарсан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, иргэдийн бүлгийн төлөөллүүдтэй бүлгийн ярилцлага зохион байгуулах, иргэд олон нийттэй зөвлөлдөх уулзалтуудыг хийх арга замуудаар мэдээллүүдийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

ОНЖДХ-нь 4 зорилт 13 чиглэл 34 үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас 21 ажил буюу 61,8 % хэрэгжсэн, үүнээс гадна төлөвлөгдөөгүй 5 ажил хийгдсэн байна. ОНЖДХ-ийн хүрээнд төлөвлөгдөөд хэрэгжсэн үйл ажиллагаанаас хохирогчдыг хамгаалах байр, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд, эрэгтэйчүүдийн кабинет байгуулагдаж, хүний нөөцийн орон тоог бий болгож ажиллуулсан зэрэг ажлууд нилээд үр дүнтэй, орон нутагт хэрэгтэй ажил болсон байна. Эдгээрээс онцлоход, эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулж, эрэгтэйчүүдийн эмчийг сургалтанд хамруулж мэргэшүүлсэн нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ, зөвлөгөө нэмэгдсэн байна.

ОНЖДХ-т төлөвлөгдөөгүйгээр хийгдсэн үйл ажиллагаанд ХХҮГ-аас хэрэгжүүлсэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагаа, ГБХЗХГ-аас зохион байгуулсан эрэгтэйчүүдийн чуулган болон аавуудад чиглэсэн үйл ажиллагаа, гэрлэх ёслолыг орон нутагт зохион байгуулдаг болсон зэрэг үр дүнтэй ажлууд хийгдсэн байна.

Оролцооны үнэлгээний үр дүнд орон нутгийн иргэдээс авсан асуулгаас үзэхэд ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжийн үнэлгээнд судалгаанд оролцогчдын 56.3 хувь нь “ОНЖДХ-ийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаанд оролцож байгаагүй тул мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь цаашид ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн бүлэг, цаашлаад хүн бүрт хүргэхэд онцгой анхаарах хэрэгтэйг харууллаа.

ОНЖДХ-ийн хэрэгжилт, үр дүнгийн талаар орон нутгийн шийдвэр гаргагчидтай хийсэн ярилцлагаас дүгнэж үзэхэд ОНЖДХ-өөс төлөвлөгдсөн хэрнээ орхигдсон ажлууд нь уул уурхайтай хамтран ажиллах, уул уурхайд ажиллагсдын гэр бүл рүү хандсан бодлого үйл ажиллагаа хийх, олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хувийн хэвшлийнхэн, ажилгүй

иргэд, малчид, уул уурхайн салбарын ажиллагсдад зохион байгуулах, хүйсээр ангилсан мэдээлэл судалгаа хийх, сургагч багш бэлтгэх зэрэг ажлууд төлөвлөсөн түвшинд хийгдээгүйг дурдсан бөгөөд хэрэгжээгүй орхигдсон шалтгаан нь Ковид19-тэй холбоотой хөл хорио, аймгийн салбар хороо цөөн хуралдсан, тодорхой шийдвэр гаргах, хяналт тавих талаар хангалтгүй ажилласан, салбар зөвлөлүүд төсөвгүй, жигд ажиллаагүй зэрэг шалтгаанаас болсныг тодорхойлсон.

Бүлгийн ярилцлагаас үзэхэд ОНЖДХ, хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар зарим нэг оролцогч сонссон гэх ба ихэнх иргэд энэ талаар мэдэхгүй байсан нь жендэрийн талаар сургалт мэдээлэл явуулдаг ч иргэн бүртээ хүрч чаддаггүй, хүртээмжтэй биш байгааг харуулж байна.

ОНЖДХ-т хийсэн баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд жендэрийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд аймаг сумдын ЗДТГ-н төрийн албан хаагчид, Политехникийн коллежийн оюутнууд, цэцэрлэг, сургуулийн багш нар, цэргийн ангиудын алба хаагчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажиллагсад, ИНБ-ын ажиллагсад, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэд илүү оролцож, үр шим хүртсэн байна.

Харин ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн ажиллагсад, ажилгүй иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уул уурхайд ажиллагсад тэдний ар гэрийнхэн төдийлөн сайн оролцож чадахгүй орхигдсон байна.

Эндээс харахад ОНЖДХ-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэхдээ төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийнхэн, ИНБ-хан гэх мэт нийгмийн идэвхтэй бүлгүүдэд түлхүү хүргэж, харин мэдээлэл дутмаг, алслагдсан болон нийгмийн идэвх сул иргэдэд хүргэх, тэднийг идэвхжүүлэх тал дээр төдийлөн сайн ажиллаж чадаагүй байна гэж дүгнэлээ.

Энэхүү дүгнэлтүүдэд үндэслэн ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой болгох, төсөв санхүүг нэмэгдүүлэх, орон нутгийн жендэрийн салбар хороог идэвхжүүлэх, орхигдсон бүлгүүдэд үйл ажиллагааг чиглүүлэх талаар бодлогын зөвлөмж боловсруулж ажиллалаа.

Нэг. УДИРТГАЛ

1.1 Үндэслэл: Өмнөговь аймгийн ИНБ-уудаас бүрдсэн ОХШҮ-ний баг 2020 оны 10 сараас эхлэн 2021 оны 01 сарын 25 хүртэлх хугацаанд ажиллаж, орон нутгийн жөндөрийн дэд хөтөлбөрийн төлөвлөлт, үйл ажиллагааны үр дүн өгөөж, цаашид засч сайжруулах асуудлыг тодорхойлохоор оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг аргачлалын дагуу гүйцэтгэж ажиллалаа. Үүнд:

ОНЖДХ-өөр дэвшүүлсэн зорилго, зорилтууд ямар асуудал руу анхаарсан, дэвшүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн, оролцогчид, үр шим хүртэгчид нь хэн байсан, хэнд чиглүүлсэн, хэдий хугацаанд, ямар эх үүсвэрээс санхүүжүүлсэн, хэрэгжилтийг хэн хангаж ажилласан, хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийсэн, хэдий хугацаанд ямар, ямар үйл ажиллагааг төлөвлөсөн, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хэр үр дүнтэй байсан, цаашид засч сайжруулах асуудлын хүрээг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлж, оролцооны хяналт шинжилгээний аргууд болох баримт бичгийн шинжилгээ, иргэд олон нийт, ОНЖДХ-ийг хэрэгжүүлэгч шийдвэр гаргагчдын санал бодлыг судалж, тэдний оролцоонд тулгуурлаж дүн шинжилгээг хийж ажилласан бөгөөд энэ нь энэхүү ОХШҮ-ний давуу тал болсон гэж үзэж байна.

1.2 Зорилго, зорилтууд: ОНЖДХ-т ОХШҮ хийхдээ ОНЖДХ-ийн үр дүнг тодорхойлох, цаашид сайжруулах асуудлыг тодорхойлох зорилгыг тавьж, энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажилласан.

- a) ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тодорхойлох
- b) ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлтийн хэмжээ, зарцуулалтыг тодруулах
- c) Төлөвлөсөн загвар нь хэрэгжилтэд нөлөөлж буйг тодорхойлох
- d) ОНЖДХ-ийн шалгуур үзүүлэлтийн оновчтой байдлыг тодруулах
- e) Өмнөх хяналт шинжилгээний үр дүнд тулгуурлан ямар өөрчлөлт оруулсан болохыг тодорхойлох
- f) Оролцогчид болон үр шим хүртэгчдийг тодруулах

1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ: ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, санхүүжилтыг тодорхойлох, хөтөлбөрийн төлөвлөлтийн загварыг сайжруулах, үр шим хүртэгчдийг тодорхойлох хүрээнд дараах асуудлыг шинжлэхээр төлөвлөсөн.

1. ОНЖДХ-ийн хэрэгжилт ямар байна вэ, үр дүн хангалттай байж чадсан уу?
2. ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлт хангалттай байсан уу? Ямар үйл ажиллагааг санхүүжүүлээд алийг нь орхигдуулж байна вэ? Яагаад?
3. ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загвар нь хэр оновчтой байна вэ?
4. ОНЖДХ-ийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт байна уу? Оновчтой эсэх?
5. Хяналт шинжилгээний ямар дүгнэлт гаргасан байна вэ? Үр дүнд нь ямар өөрчлөлт гарсан бэ?
6. Хэн оролцоод, хэн үр шим хүртсэн байна вэ?

Хоёр. ОХШҮ-НИЙ АРГА ЗҮЙ

2.1 Мэдээлэл цуглуулах аргууд: Мэдээлэл цуглуулах ажлыг дараах аргуудаар гүйцэтгэсэн.

Үүнд:

1. Баримт бичиг шинжлэх арга
2. Асуулгын арга
3. Түлхүүр мэдээлэгчтэй ярилцах арга
4. Бүлгийн ярилцлагын арга

2.1.1 Баримт бичиг шинжлэх арга:

Баримт бичиг шинжлэх аргаар ажиллахдаа ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрүүд, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, хугацаа, төсөв санхүүжилт, хэрэгжүүлэгч байгууллага, ТББ болон хэвлэл мэдээллийн оролцоо зэрэг мэдээллийг нягтлахаар дараах 12 төрлийн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн.

Үүнд:

Хүснэгт-1: Баримт бичгийн жагсаалт

Д/д	Баримт бичиг
1	ОНЖДХөтөлбөр / <i>төлөвлөлт, үе шат</i> /
2	ОНЖДХ –ийн хэрэгжилтийн тайлан 2019, 2020 он
3	Аймгийн ИТХ-ын холбогдох тогтоолууд / ОНЖДХ батласан тогтоол, бусад тогтоол гарсан эсэхийг харна /
4	Аймгийн 2020 оны үндсэн чиглэл
5	Аймгийн Засаг дарга болон ЗДТГ-аас ОНЖДХ-тэй холбогдон гарсан , захирамж, тушаал
6	ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлт санхүүжилт холбогдох шийдвэрүүд
7	ХШҮ хийсэн тайлан дүгнэлт зөвлөмж үр дүн 2019 он
8	Оролцогч талуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ , хэрэгжилт, тайлан 2019, 2020 он / <i>хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ</i> /
9	ОНЖДХ-ийн хэрэгжилтийг тайлагнасан хурлын тэмдэглэл / <i>ИТХТэргүүлэгчдэд 2 жил тутам тайлагнасан бол хурлын тэмдэглэл байгаа эсэхийг тодруулах</i> /
10	Сумдад жендэрийн салбар зөвлөл байгуулагдсан шийдвэр
11	Сумдын салбар зөвлөлийн ажлын тайлангууд 2019, 2020 он
12	Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тайлан 2019,2020 он / эрэгтэйчүүдийн кабинетийн үйл ажиллагааны тайлан /

2.1.2 Асуулгын арга:

Асуулгын аргыг иргэдээс мэдээлэл цуглуулахад ашигласан. Асуулгыг 20 асуулттайгаар боловсруулж, нийт 200 хүнийг оролцуулсан бөгөөд 100 хүнээс нь цахимаар / google form / , 100 хүнээс асуулгыг цаасан хэлбэрээр авсан.

Асуулгыг иргэдээс авахдаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны улирлын шинж чанартай ажил эрхлэгч, эрхэлсэн ажилгүй 18-40 хүртэлх насны эрэгтэйчүүд, залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, малчдын бүлэг нөхөрлөл хоршоодын ахлагч нар, орон нутгийн манлайлагчид зэрэг иргэдийн бүлгийн төлөөллийг хамруулж, тэдний

жендэрийн талаарх ойлголт, ОНЖДХ-ийн талаарх ойлголт, хөтөлбөрөөс ямар үр шим хүртсэн эсэхийг тодорхойлох зорилгоор ашиглав.

2.1.3 Түлхүүр мэдээлэгчтэй ярилцах арга:

Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч буюу жендэрийн салбар хорооны дарга, НБХ-ын дарга, НБХ-ийн Жендэрийн мэргэжилтэн, ГБХЗХГазрын дарга нарыг хамруулж, ОНЖДХ-т дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаанаас юу нь хэрэгжээд, юу нь хэрэгжихгүй байгаа, үүнд юу нөлөөлсөн болох, ОНЖДХ-ийн төсөв, санхүүг батласан байдал, тайлагналт, хяналт шинжилгээ хийгдсэн эсэх талаарх нарийвчилсан, дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахдаа тус аргыг ашигласан.

2.1.4 Бүлгийн ярилцлагын арга:

Бүлгийн ярилцлагын аргыг ОНЖДХ-өөс үр шим хүртэгчдээс мэдээлэл цуглуулахад ашиглаж, залуучууд, малчид, эмэгтэйчүүд, ИНБ-ын төлөөлөл гэсэн дөрвөн бүлгийг оролцуулж, дөрвөн удаагийн бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, 24 хүнийг хамруулсан.

2.2 Түүвэрлэлт

Хэрэгцээтэй мэдээлэл өгч чадах хүмүүсийг сонгон нийт **236** хүнээс мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн.

Үүнд:

- Асуулгад 200 иргэн (нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны улирлын шинж чанартай ажил эрхлэгч, эрхэлсэн ажилгүй 18-40 хүртэлх насны эрэгтэйчүүд, залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, малчдын бүлэг нөхөрлөл хоршоодын ахлагч нар, орон нутгийн манлайлагчид)
- Ганцаарчилсан ярилцлагад жендэрийн мэргэжилтэн, шийдвэр гаргагчид болох аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, НБХ-ийн дарга, ГБХЗХГ-ын дарга гэсэн нийт зургаан хүнийг хамруулах
- Бүлгийн ярилцлагад үр шим хүртэгчдийн төлөөлөл болох залуучууд, эмэгтэйчүүд, малчид, ИНБ-ын төлөөлөл гэсэн дөрвөн бүлгийн нийт 30 хүн

Хүснэгт-2: Түүвэрлэлт

Сонгосон аргууд	Сонгосон эх сурвалжууд			
	Жендэрийн мэргэжилтэн	Шийдвэр гаргагчид	Хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Иргэд
Асуулга				200
Ганцаарчилсан ярилцлага	1	5		
Бүлгийн хэлэлцүүлэг			5 бүлэг (6хүн)	30
236 хүн				

2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа

Мэдээлэл цуглуулалтын ажлыг дараах байдлаар төлөвлөж, 2020 оны 12 сарын 08-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд 3-5 хүний бүрэлдэхүүнтэй 3 баг болгон зохион байгууллаа.

Хүснэгт-3: Мэдээлэл цуглуулалтын ажлын төлөвлөгөө

Д/д	Судалгааны нэр	Хугацаа	Хийгдэх газар /сумаар/	Хамруулсан хүний тоо	Судалгаа авах багийн гишүүд
1	Асуулга	12/08-20	15 сум	199	Ахлагч М.Ууганцэцэг

					5 хүнтэй баг
2	Ганцаарчилсан ярилцлага	12/08-20	Даланзадгад	6	Ахлагч Б.Цэрэнлхам 3 хүнтэй баг
3	Бүлгийн хэлэлцүүлэг	12/08-20	<ul style="list-style-type: none"> • Даланзадгад-ИНБ, залуучууд • Ханхонгор-малчдын бүлэг • Баяндалай-эмэгтэйчүүд 	24	Ахлагч Д.Мядагсүрэн 3 хүнтэй баг
Хамруулсан хүний тоо:				229	

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаандаа хувь хүний үзэл бодлыг хүндэтгэх, судалгааны зорилго, ач холбогдлыг тайлбарлаж ойлгуулах замаар оролцогчдыг сайн дурын үндсэн дээр судалгаанд хамруулах, судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг нууцлах, судалгаа авах явцад судалгаанд оролцогчдод хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх зэрэг ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан.

Асуулгын мэдээлэл цуглуулалтад нийт 200 хүнийг хамруулахаар төлөвлөсний дагуу ажиллаж хөл хорионы нөхцөл байдалтай холбогдуулан 100 хүнээс нь гүүгл форм ашиглан аймгийн 15 сумын иргэдийн төлөөллийг оролцуулсан нь өргөн хүртээмжтэй ажил болсон гэж үзэж байна. Асуулгыг цахимаар авахад асуулга бүрийг орхигдуулахгүй бөглүүлэхэд анхаарч программын тохиргоог хийх, иргэдээс авахаас өмнө өөрсдөө бөглөж хянаж үзэх зэргээр ажиллав.

Асуулгыг мөн цаасаар хэвлэн багийн гишүүд хуваарилан авч, 100 хүнээс мэдээлэл цуглуулсан. Асуулгыг цаасаар мэдээлэл цуглуулахад асуулгыг бөглөх заавар маш ойлгомжтой байх, асуулгын асуулт бүр заавартай байх, асуулгад оролцогчийн хажууд байж шаардлагатай тохиолдолд зөвлөн туслах, асуулгыг бүрэн бөглөсөн эсэхэд хяналт тавих зэрэг сургамжтай зүйлсийг олж авсан.

Асуулгад иргэдийн төлөөлөл 200 хүнийг хамруулан 20 асуултыг дэвшүүлэн мэдээллийг цуглуулж нэгтгэлээ.

Асуулгад оролцогчдын мэдээлэл: Асуулгад оролцогчид насны хувьд 18-75 насныхан жигд оролцсон, хүйсийн хувьд 40 хувь нь эрэгтэй, 60 хувь нь эмэгтэй, ажил эрхлэлтийн байдал төрийн албан хаагч 23 хувь, хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхлэгч, улирлын чанартай ажил эрхлэгч, малчин ногоочин, тэтгэвэрийн, оюутан, эрхэлсэн ажилгүй гэх мэт бүлгийн төлөөллүүд дундажаар тус бүр 7-9 хувьтай оролцсон, нутаг дэвсгэрийн байршлын хувьд Даланзадгад сумаас 37 хувь, бусад 14 сумдаас тус бүр 4-6 хувьтай оролцсон байна. Эндээс үзэхэд нас хүйс, ажил эрхлэлтийн байдлаараа иргэдийн төлөөллийг бүрэн хангаж, нутаг дэвсгэрийн байршлаараа аймгийн 15 сумыг бүрэн хамруулж, судалгааны хамрах хүрээ өргөн хийгдсэн гэж үзэж байна.

Иймд судалгаанд оролцогчдын нас, ажил эрхлэлт, байршлаар нь ангилан авч үзэх шаардлагагүй гэж үзэж, судалгааны нийт дүнг дүгнэлт шинжилгээндээ ашигласан болно.

Ганцаарчилсан ярилцлагыг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч буюу жендэрийн салбар хорооны дарга, НБХ-ын дарга, НБХ-ийн жендэрийн мэргэжилтэн, ГБХЗХГ-ын дарга нар гэсэн зургаан хүнийг оролцуулж, ОНЖДХ-т дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаанаас юу нь хэрэгжээд, юу нь хэрэгжээгүй, түүний учир шалтгаан, төсөв санхүүг

баталсан байдал, тайлагналт, хяналт шинжилгээ хийгдсэн эсэх талаар 12 асуултын хүрээнд зохион байгуулсан.

Бүлгийн ярилцлагыг малчдын бүлэг, эмэгтэйчүүд, залуучууд, иргэний нийгмийн байгууллага гэсэн 4 чиглэлээр Даланзадгад, Ханхонгор, Баяндалай сумдын иргэдийн төлөөллийг хамруулан нэг бүлэгт 6 хүн оролцуулан нийт 24 хүнийг оролцуулж, жендэрийн талаарх мэдлэг ойлголт, ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд оролцсон эсэх, эрэгтэй эмэгтэй хүмүүст тулгамдаж байгаа асуудал, цаашид ОНЖДХ-ийг хэрэгжилтийг сайжруулах санал зэрэг 8 асуултын хүрээнд зохион байгуулсан.

Ярилцлагад оролцогчдыг хүйсээр авч үзвэл 17 нь эмэгтэй, 7 нь эрэгтэй, насаар авч үзвэл 30 хүртэл насны 7, 30-40 насны 4, 40-60 насны 9, 60-аас дээш насны 4 байлаа.

2.4 Зөвлөлдөх уулзалт:

ОНЖДХ-т ОХШҮ хийх зорилго, зорилт, арга зүй, аргачлалын талаар иргэд, олон нийттэй зөвлөлдөх уулзалтыг нэг удаа цахимаар, нэг удаа танхимаар зохион байгуулж, нийт хоёр удаагийн зөвлөлдөх уулзалтад нийт 15 хүнийг хамруулсан.

2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Даланзадгад суманд цахим зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, иргэдийн төлөөлөл гурав, ИНБ-ын төлөөлөл-гурав, төрийн албан хаагчдын төлөөлөл дөрөв, нийт 10 хүнийг хамруулсан.

2020 оны 12 сарын 10-ны өдөр Өмнөговь аймгийн Цогт-овоо суманд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, иргэдийн төлөөлөл, жендэрийн салбар зөвлөлийн гишүүд таван хүнийг хамруулсан.

Зөвлөлдөх уулзалтаар ОНЖДХ, түүнд ОХШҮ хийх талаар мэдээллийг өгч, ОХШҮ хийхдээ хэрэглэх арга, аргачлал, хамруулах иргэдийн төлөөллүүд, үр шим хүртэгчид, цаашид ОНЖДХ-ийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний талаар зөвлөлдсөн. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдоос дараах саналууд гарсан. Үүнд:

- ОНЖДХ-ийн хэрэгжилтийн үр дүн, хүртээмжийг үнэн бодит үнэлэхэд анхаарах
- Иргэдийн бүлгийн төлөөллийг орхигдуулалгүй хамруулах
- Иргэд олон нийтийн жендэрийн талаарх зөв мэдлэг ойлголтын түвшинг үнэн зөв тодруулах
- ОНЖДХ-ийг хэрэгжүүлэхэд төсөв хангалтгүй, сумдын салбар зөвлөл төсөв байхгүй байгааг анхаарах
- Төрийн албан хаагчид, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулах
- Цаашид хийх ямар үйл ажиллагааг зохион байгуулбал иргэдийн оролцоо нэмэгдэх талаар судалгаа хийх
- ОНЖДХ-ийг сайжруулах, үйл ажиллагааг хүртээмжтэй болгоход анхаарах
- Орон нутгийн ИТХ шинээр байгуулагдаж, аймгийн хөгжлийн хөтөлбөрийн баримт бичгүүд боловсруулагдаж байгаатай холбогдуулан жендэрийн хөтөлбөрийг сайжруулах саналыг гаргаж хүргүүлэх

зэрэг саналууд гарсан.

Иймд зөвлөлдөх уулзалтын үр дүн, санал санаачилгад үндэслэн ОНЖДХ-ийг сайжруулах, төсөв санхүүг нэмэгдүүлэх, олон талт оролцоог хангах чиглэлээр аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөнд тусгах, хамтран ажиллах саналыг боловсруулж, аймгийн

ИТХ-ын дарга, ИТХ дахь намын бүлгүүдэд албан тоотоор хүргүүлсэн. / албан тоотыг хавсаргав /



Зураг-1: Цахим зөвлөлдөх уулзалт



Зураг-2: Цахим зөвлөлдөх уулзалт явц



Зураг-3: Цогт-овоо сумын зөвлөлдөх уулзалт

Гурав. ОХШҮ-НИЙ ҮР ДҮН

3.1 Оролцооны хяналт шинжилгээний үр дүн

ОХШ-ний маягтаар ОНЖДХ-ийн зорилго зорилт, төлөвлөлт, хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх зорилгоор хөтөлбөрийн загвар хэр оновчтой, хичнээн үйл ажиллагаа төлөвлөж хэдэн хувь хэрэгжсэн, хэрэгжүүлсэн ямар үр дүн гарсан, суурь түвшний мэдээлэл, шалгуур үзүүлэлт байгаа эсэх, төсөв хэрхэн шийдэгдсэн тухай, мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 9 сарын 5 -ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан ОНЖДХ-т дөрвөн зорилт, 13 чиглэл, 34 үйл ажиллагааг 2018-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хөтөлбөр батлагдсанаас хойш 2020 оны 12 сар хүртэлх

хугацаанд төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас 21 ажил буюу 61,8 % хэрэгжсэн. Энэ нь хоёр жил хийгдсэн ажлын хувьд гүйцэтгэл сайн хэдий ч, үр дүн хангалттай биш гэж дүгнэсэн.

Төлөвлөгдсөн болон төлөвлөгдөөгүй хэрэгжсэн үйл ажиллагааг аймаг сумдын жендэрийн салбар хороо, зөвлөл, Аймгийн ЗДТГазар, ГБХЗХГазар, Хүний эрхийн комисс, ИНБ-ууд, Насан туршийн боловсрол төв, БОЭТ гэх мэт байгууллагууд хэрэгжүүлж сумдын засаг дарга нар, төрийн албан хаагчид, холбогдох агентлаг албан байгууллага хэвлэл мэдээллийнхэн, Политехникийн коллеж, цэцэрлэг, сургууль, цэргийн ангиуд оролцож, 10895 хүнд сургалт мэдээлэл хүргэсэн байна.

Хүснэгт- 4: ОНЖДХ-ийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл

№	Зохион байгуулагдсан сургалт, нөлөөллийн ажлын нэр	Хамрагдсан хүний тоо	хүйсээр		Хэн хамрагдсан	Мэдээлэл байхгүй
			эр	эм		
1	Жендэрийн тухай ойлголт хүйсийн сэтгэл зүй	22	-	-	СӨБ-ийн багш ажилчид	Хүйсийн мэдээлэл байхгүй
2	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	33	17	16	ЗХ-ний 167-р анги	
3	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	54	28	--	Дулааны цахилгаан станц Захирагчийн албаны ажилчид	хүйсийн мэдээлэл дутуу
3	Миний биеийн аюулгүй дүрэм	21	10	11	1-р сургуулийн сурагчид	-
4	Уул уурхайн салбар дахь ЖЭТБайдал	42			Таван толгой ХК-ны ажилчид	Бүртгэл байхгүй
5	Жендэр ба хүний эрх	35	13	22	Төрийн албан хаагчид	
6	Жендэр ба хүний эрх чадавхижуулах сургалт	45	-	-	Сумдын засаг дарга Агентлагийн дарга мэргэжилтэн нар	Мэдээлэл дутуу
7	Уул уурхайн салбар дахь ЖЭТБ ба хөдөлмөр эрхлэлт	2100	-	-	Цогтцэций Ханбогд Гурвантэс сумдын залуучууд иргэд	Мэдээлэл дутуу
8	Хүүхдийн боловсролоос тусгаарагдаж буй шалтгаан бэрхшээл	55	26	29	Хүүхэд хамгаалалын ажилтан . багш эцэг эхийн төлөөлөл боловсролын удирдлага ИНБ-ууд	
9	Жендэрийн талаар ярилцъя сургалт хэлэлцүүлэг	20	-	20	Говийн ээжүүдийн хөгжлийн клуб	

10	Жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх	400			Политехникийн коллежи, багш нийгмийн ажилтан	мэдээлэл байхгүй
11	Жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах	350	350		15 сумдын төлөөлөл эрэгтэйчүүд	
12	Жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах	7600			Цэргийн ангиуд ЕБС, цэцэрлэг, ТББ коллежи	сургалт хийсэн 3 газарт
13	Жендэрийн үндсэн ойлголт ба хөдөлмөр эрхлэлт	60	14	46	Ханхонгор Даланзадгад Баяндалай сумдын иргэд	
14	Дундаж наслалт дахь жендэрийн зөрүү ба эрэгтэйчүүдийн эрүүл мэнд	58	58		Онцгой байдлын газар, цагдаагийн газар, Даланзалгад сумын ЗДТГазар	
	Дүн:	10895				

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй байна.

Дээрх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанаас гадна эрэгтэйчүүдийн кабинетаар 3900 хүн үйлчлүүлж, орон нутгийн телевизээр 8 цуврал 16 удаагийн нэвтрүүлэг хийж 8800 хүнд масс мессеж илгээсэн байна.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр”-ыг 2019 онд байгуулж, 2020 онд 90 хүүхэд, 32 насанд хүрэгчдэд 278 хоногийн үйлчилгээг үзүүлжээ. Мөн ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэд, охид эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сэтгэл зүйчдийг бэлтгэж, 20 хүнийг гэр бүл судлаач, сэтгэл зүйчээр магистрт сурган төгсгөж, 2020 онд аймгийн ЗДТГ-аас тэдний сургалтын төлбөрт 20 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна. Тус гэр бүл судлаач, сэтгэл зүйч 20 хүнээс 11 хүн нь аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн, Залуучуудын хөгжлийн төвийн ажилтан, нэг хүн аймгийн НТБТ-д ажилладаг, гурван хүн нь ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, таван хүн нь бусад мэргэжлийнхэн байна.

Үүнээс гадна мөн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх хоёр төв, эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулж, ажиллагсадын орон тоо батлагдан ажиллаж эхэлсэн байна. Эрэгтэйчүүдийн эмчийг сургалтанд хамруулж мэргэшүүлснээр эрэгтэйчүүдийн үзлэг үйлчилгээ нэмэгдсэн үр дүн гарчээ.

Хүснэгт-5: ОНЖДХ-т хамаарах төлөвлөгдөөгүй хэрэгжсэн үйл ажиллагаа, түүнд оролцогчид

1	Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр	1.Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 198-р тогтоолоор 2020 оныг “Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон зарласан	2020	АИТХ, АЗД, АЗДТГ	950.0 сая	500 өрхийг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулсан
---	--	--	------	------------------	-----------	---

	судалгаа шинжилгээ хийх, сургалт арга хэмжээ зохиох	2.Ахмад настан ХБИ, өрх толгойлсон иргэдийн , хөгжил хамгааллыг сайжруулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2019, 2020	АЗД-ын “Бид хамтдаа” хөтөлбөр	буцалтгүй дэмжлэг 102,3 сая	68 ахмад, 15 өрх толгойлсон эцэг эх, 26 хөгжлийн бэрхшээлтэй иргэн
3	Олон нийтэд жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах мэдлэг олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулах	1.Аймгийн эрэгтэйчүүдийн анхдугаар чуулган зохион байгуулсан.	2019	Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ	12,0 сая	15 сумаас 350 төлөөлөгчид
		2.”Халамжит аав” арга хэмжээ зохион байгуулсан	2019	ГБХЗХГ, залуучууд хөгжлийн төв	448.0 мян	Жирэмсний хяналттай эмэгтэйчүүдийн 35 хүртэлх насны 15 нөхөр
		3.Гэр бүлийн үнэ цэнийг мэдрүүлэх монгол ёс заншлыг дэлгэрүүлэх зорилгоор “Гэрлэх ёслол”ын арга хэмжээг хийж хэвшүүлсэн	2019, 2020	Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ залуучууд хөгжлийн төв		2019 үнд 7, 2020 онд 20 гэр бүл, нийт 27 гэр бүлийг хуримлуулсан

Иргэд, олон нийтийн жендэрийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлууд нилээд ажлууд хийгдсэн ч хүртээмж, үр өгөөж тал дээр анхаарахаар байна. ЖЭТБ-ыг хангах ажлыг зохион байгуулах ,мэргэжилтэн боловсон хүчнийг чадавхижуулах хамтын үйл ажиллагааг сайжруулах, хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг салбар бүрээр хийх шаардлагатай гэж дүгнэв.

Хүснэгт-6: Төлөвлөгдөөд хэрэгжээгүй ажлууд

№	Хэрэгжээгүй үйл ажиллагаа	Шалтгаан
1	Шийдвэр гаргах түвшинд хүйсийн зохистой харьцааг бий болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Аймаг, сумдын жендэрийн салбар хороо, зөвлөлүүдийн ажил тогтвортой биш байгаагаас хийгдээгүй гэж үзсэн
2	Жендэрийн эрх тэгш байдлыг харуулсан урлагийн бүтээл туурвих	Төсөв мөнгө тавигдаагүйгээс хийгдээгүй

ОНЖДХ-ийн хэрэгжилт, үр дүнгийн талаар орон нутгийн шийдвэр гаргагчидтай хийсэн ярилцлагаас дүгнэж үзэхэд ОНЖДХ-өөс төлөвлөгдсөн хэрнээ орхигдсон ажлууд нь уул уурхайтай хамтран ажиллах, уул уурхайд ажиллагсадын гэр бүл рүү хандсан бодлого үйл ажиллагаа хийх, олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголт , хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, хүйсээр ангилсан мэдээлэл судалгаа хийх, сургагч багш бэлтгэх зэрэг ажлууд хангалттай төлөвлөсөн түвшинд хийгдээгүйг дурдсан бөгөөд хэрэгжээгүй орхигдсон шалтгаан нь жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн орон тоогоор ажилладаггүй, Ковид19-тэй холбоотой хөл хорио, аймгийн салбар хороо цөөн хуралдсан, тодорхой шийдвэр гаргах, хяналт тавих талаар хангалтгүй ажилласан, салбар зөвлөлүүд төсөвгүй, сум бүрт бүрэн байгуулагдаагүй зэрэг шалтгаанаас болсныг тодорхойллоо.

.... Эх сурвалж. Ганцаарчилсан ярилцлагаас: Өмнөговь аймгийн ГБХЗХГ-ын дарга Б.Эрдэнэцэцэг “ГБХЗХГ-аас ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр иргэд, олон нийт тэр

дундаа залуучуудын жендэрийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлууд тасралтгүйгээр хийгдэж байгаа. Миний хувьд ОНЖДХ-ийн үйл ажиллагааг сайжруулахад энэ чиглэлээр хүний нөөцийг нэмэгдүүлэх өөрөөр хэлбэл жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнг орон тоогоор ажиллуулах шаардлагатай гэж үздэг. Ингэснээр жендэрийн салбар хороо, сумдын салбар зөвлөлүүдийн ажил идэвхжих юмаа”

Аймгийн ЗДТГ-аас 2019 онд орон нутгийн ИНБ-уудаар ОНЖДХ-т хяналт шинжилгээ хийлгэсэн. Тус хяналт шинжилгээний үр дүн, дүгнэлт зөвлөмжид нь үндэслэн, 2020 оны ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлт нэмэгдсэн үр дүн гарсан.

Хүснэгт-7: ОНЖДХ-ийн төсвийн үзүүлэлтийн график



Аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны А\152 дугаар тушаалаар ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2 сая төгрөгийг төсвийн хуваарьт тохируулан ажлын гүйцэтгэлд үндэслэн холбогдох зардлаас санхүүжүүлсэн байв.

Аймгийн ИТХ-ын Хурлын 2019 оны 12 сарын 4 –ний 9\3 дугаар тогтоолын 2-р хавсралт 2020 оны үндсэн чиглэлийн 40 дэх хэсэгт жендэрийн тэгш эрхийг ханган үйл ажиллагаа зохион байгуулах 25 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан.

Аймгийн ИТХ-ын Хурлын 2020 оны 12 сарын 3- ны 2\8 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээний 23-р зүйлд ЖЭТБ-ыг хангах үйл ажиллагааг зохион байгуулахад 25 сая төгрөг баталсан. Эх сурвалж. *Өмнөговь аймгийн ИТХ-ын тогтоолоос*

Бүлгийн ярилцлагаас үзэхэд малчид, эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллүүд ОНЖДХ-ийн талаар зарим нэг оролцогч сонссон гэх ба ихэнх иргэд энэ талаар мэдэхгүй байсан нь жендэрийн талаар сургалт мэдээлэл явуулдаг ч төдийлөн хүртээмжтэй биш байгааг харуулж байна гэж үзлээ.

ОНЖДХ-ийн хэрэгжилтийн 8 шалгуур үзүүлэлт байгаа боловч дэвшигдсэн асуудлын суурь түвшний мэдээлэл байхгүй учир харьцуулан шинжлэх боломжгүй байв. Жишээ нь : шалгуур үзүүлэлтийн 4-т Жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийн тоо 10 дахин нэмэгдсэн байна гэж төлөвлөсөн ч суурь үзүүлэлт байхгүй байна Мөн шалгуур үзүүлэлтийн 2, 6 дахь заалтууд суурь үзүүлэлтгүй байв.

Дүгнэлт: ОНЖДХ-ийн үйл ажиллагаа нь дөрвөн зорилт, 13 чиглэлийн 34 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулагдсан бөгөөд хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж үзэхэд

хэрэгжээгүй ажил 7, хэрэгжсэн 27 ажлын гүйцэтгэлийн дундаж нь 61,8 хувьтай байна. Мөн ОНЖДХ-т хамаарах төлөвлөгдөөгүй хэрэгжсэн 5 ажил, төлөвлөгдсөн боловч хэрэгжээгүй 7 ажил байгаа нь цаашид ОНЖДХ-ийн төлөвлөлтийг оновчтой болгоход зайлшгүй анхаарах шаардлага байгааг харуулж байна гэж дүгнэлээ.

Ингээд иргэдээс авсан асуулга, шийдвэр гаргагчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагууд, баримт бичгийн шинжилгээнээс ОНЖДХ-ийн хэрэгжилт хангалттай, үр дүнтэй байж чадсан эсэхийг дүгнэж үзэхэд **“ОНЖДХ-ийн хэрэгжилт хангалтгүй, үйл ажиллагааны хүртээмж муу, мэдээ мэдээлэл дутмаг”** гэсэн дүгнэлтийг гаргалаа.

3.2 Оролцооны үнэлгээний үр дүн

ОХШ-ний мэдээллийг шинжилсний үр дүнд ОУ хийх тодорхой асуудлууд гарч ирсэн бөгөөд эдгээр тодорхой асуудлууд дээр тулгуурлан үнэлгээний баг оролцооны үнэлгээг хийж үр дүнг танилцуулж байна.

1. ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлт хангалттай байсан уу? Ямар үйл ажиллагааг санхүүжүүлээд алийг нь орхигдуулж байна вэ? Яагаад?
2. ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загвар нь хэр оновчтой байна вэ?
3. ОНЖДХ-ийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт байна уу? Оновчтой эсэх?
4. Хяналт шинжилгээний ямар дүгнэлт гаргасан байна вэ? Үр дүнд нь ямар өөрчлөлт гарсан бэ?
5. Хэн оролцоод, хэн үр шим хүртсэн байна вэ?

ОНЖДХ-т оролцооны үнэлгээг хийхдээ асуулга, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргыг ашиглан иргэд, шийдвэр гаргагчид, иргэдийн бүлгийн төлөөллийн санал бодлыг авсан болно.

3.2.1 ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлт хангалттай байсан уу? Ямар үйл ажиллагааг санхүүжүүлээд алийг нь орхигдуулж байна вэ? Яагаад?

ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлтийн талаар баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд ОНЖДХ нь 2018 онд батлагдаж, 2019 онд 2.0 сая, 2019, 2020 онуудад тус бүр 25.0 сая төгрөг батлагдсан нь төсвийн хувьд мөнгө, санхүүг төлөвлөх байдалд анхаарч байгаа нь харагдсан боловч хөтөлбөрийн үйл ажиллагааг орон нутгийн нийт иргэдэд хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг төлөвлөх тал дээр анхаарах шаардлагатай гэж үзэж байна (Хүснэгт 15).

Ямар ажил санхүүжигдэж, ямар ажил орхигдож байгаа талаар авч үзэхэд сургалт нөлөөлөл, иргэн бүр нийгмийн хөгжлөөс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг голчлон санхүүжүүлсэн. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх, судалгаа үнэлгээг салбар бүрээр хийх, сургагч багш бэлтгэх чадавхжуулах ажлууд орхигдсон. Энэ нь төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалсан гэж үзэв.

Хүснэгт-8: ОНЖДХ-ийн хүрээнд санхүүжигдсэн болон санхүүжигдээгүй үйл ажиллагаа

Үйл ажиллагаа		Хэрэгжсэн үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв	Үр шим хүртэгчдийн төрөл, тоо	Хэрэгжээгүй шалтгаан, тайлбар
1	Сумдын жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг нь тогтмолжуулах,	1.Аймгийн 7 суманд жендэрийн салбар хороо байгуулагдсан	1,200,0	Тухайн сумдын иргэд	Үлдсэн 8 суманд зөвлөл бий эсэх тухай нотлох баримтгүй

	мэргэжил арга зүйгээр хангаж чадавхижуулах				
2	Жендэрийн тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, үндэсний болон дэд хөтөлбөрийн тайлан хэрэгжилтийг цаг угацаанд нь зохиох газарт хүргүүлэх ажлыг сайжруулах	-	Аймаг сумдын иргэд төр ТББ, хувийн хэвшил	Хэрэгжилт үр дүнг - жил бүр 12 сард тайлагнах хөтөлбөрийн 7.4 заалт хэрэгжээгүй
3	Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, сургалт арга хэмжээ зохион байгуулах	1.Хөдөө аж ахуйн салбар (малчид)-ын жендэрийн эрх тэгш байдлын судалгааны ажлыг зохион байгуулж мэдээллийн сантай болох	600.0	Аймаг сумдын Төрийн Хөдөө аж ахуйн салбар мэдээллийн сантай болох	статистикд төсөв нь шилжсэн ч хэрэгжээгүй хамтын ажиллагаа төлөвлөлт дутсан
		2."Уул уурхайн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах" сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан	3.000.0	Нөлөөллийн бүсийн сумдын 2100 хүн	Орон нутгийн төсвөөс
		3.Жендэрийн мэргэжилтэн боловсон хүчнийг чадавхижуулах " Жендэр ба хүний эрх " сургалт зохион байгуулсан	0	Салбар зөвлөл сумдаас - 20 албан байгууллагаас 25 хүн	
4	Жендэрийн эрх тэгш байдал болон хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа шинжилгээг салбар бүрээр хийж олон нийтэд мэдээлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах	1.Төрийн албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа хийсэн	0	Эрүүл мэнд боловсролд 83%-94.4 % ИТХ, УБМХ, ХХҮГ, татвар т 60.6%-72,7% эмэгтэйчүүд ажиллаж байна	Бүрэн хэрэгжээгүйтул 2020 онд 5 салбарт хийнэ гэж шалгуурт байв.
		2.Аймгийн ИТХ -ын Төлөөлөгчдийн нэгдсэн судалгаа хийсэн	0	ИТХ-ын түвшинд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь 33,4 %	бодлого төлөвлөлтөнд ашиглах хэмжээнд судалгаа бүрэн хийгдээгүй
5	Төрийн албан хаагчид болон жендэрийн мэргэжилтэнийг чадавхижуулах шат	Жендэрийн салбар зөвлөлийн гишүүд, төрийн албан хаагчид, ажилчид,	0		

	дараалсан сургалт, арга хэмжээнд хамруулж, мэргэжил арга зүйгээр хангах	жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн,нарыг чадавхжуулах сургалт нөлөөллийн цуврал ажлууд зохион байгуулсан.			
6	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэр болон жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	1.Гэр бүлийн харилцааны эерэг зөв үлгэр дууриаллыг түгээн дэлгэрүүлэх алдаршуулах зорилгоор " Хосын жор" теле цуврал нэвтрүүлэг бэлтгэж түгээсэн	1.000.0	8 цуврал нэвтрүүлэг бэлтгэн 16 удаа олон нийтэд хүргэсэн	ГБХЗХГ хамтран ажиллаж, ХМБ-тай гэрээ байгуулан ажилласан
		2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сонинд нийтлэл, тв-д шторк, цаасаар брошур хийж иргэдэд хүргэсэн	490.0	180 хүн	ОНЖДХ-ийн хүрээнд ТББ-д жижиг төслөөр хэрэгжүүлсэн
		3.Олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээлэлээр дамжуулж иргэдийн жендэрийн мэдлэг ойлголтыг дээшлүүлсэн	900.0	Пэйж группд дагагч 500 хүн, Теле хичээлд 50 хүн	ОНЖДХ-ийн хүрээнд ТББ-д жижиг төслөөр хэрэгжүүлсэн
7	Эрэгтэйчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх	1.Эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулан тохижуулж үйл ажиллагааг өргөжүүлсэн.	0	Аймаг, сумдын эрүүл мэндийн газар, нийт эрэгтэйчүүд	БОЭТ-өөс тохижилтын төсөв гарсан
		2.Эрэгтэйчүүдийн кабинетын эмч мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтанд хамруулсан.	3.000.0	БОЭТөвийн эмч мэргэжилтэн үйлчлүүлэгч нар	Эмчийг 6 сарын сургалтад хамруулсан /БОЭТ-өөс/
		3.Эрэгтэйчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулсан	3.000.0	2019 онд 3800, 2020 оны 10 сарын байдлаар 2928 хүн үзлэгт хамрагдсан	Албан байгууллага ААН –тэй хамтарч ажиллах шаардлага- тай
8	Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	1.Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хонгийн аян зохион байгуулсан	1.000.0	400 хүнд сургалт мэдээлэл хүргэж Unitel үүрэн телефоны компаниар 8800 хүнд масс мессэж илгээсэн	

9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	1.Төрийн бус байгууллагаар хяналт мониторинг хийх жижиг төсөл хэрэгжүүлэх нийтийн сонсгол зохион байгуулах асуумж судалгаа авах зэрэг ажлуудыг гэрээлэн гүйцэтгүүлж хамтран ажилласан	17.600.0	Аймгийн жендэрийн салбар хороо 10 ажлын хэсэг 15 зорилтот бүлгийн иргэд	
10	Жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх ажлыг зохион байгуулах	Сургагч багш бэлтгэсэн үйл ажиллагаа хийгдсэн тайлан байхгүй	0	Олон нийт, зорилтот бүлгүүд, төр, ТББ, хувийн хэвшлийнхэн	Хэрэгжээгүй шалтгааныг нь холбогдох хүн нь тодорхой хариу өгсөнгүй
11	Олон нийтэд жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах мэдлэг олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулах	Олон нийтэд жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах мэдлэг олгох сургалт нөлөөлөлийн ажил зохион байгуулсан	0	35 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж 7600 гаруй хүн хамрагдсан	
12	Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах	1.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр нэг цэгийн үйлчилгээ байгуулагдсан	172.000.0	2019 онд 7 гэр бүлийн 6 насанд хүрэгч 14 хүүхэд, 2020 онд 18 насанд хүрэгч, 40 хүүхэд	Орон нутгийн төсвөөс
		2.Гэр бүлд зөвлөгөө өгөх 2 төвийн үйл ажиллагааг тогтмолжуулсан	5.500.0	2019 онд 87 гэр бүлийн 255 хүн 78 хүүхэд, 2020 онд 172 насанд хүрэгч 62 хүүхэд	Орон нутгийн төсвөөс
		3.Гэр бүлд зөвлөгөө өгөх 20 сэтгэлзүйчдийг ОУ-ын Улаанбаатар их сургуулийн гэр бүл судлалын магистрын ангид суралцуулж, бэлтгэж байгаа	20.000.0	сэтгэл судлалын магистр 20 суралцагчид	Орон нутгийн төсвөөс

13	Шийдвэр гаргах түвшинд хүйсийн зохистой харьцааг бий болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	0	0		Хэрэгжээгүй Тодорхой эзэнжүүлээгүйгээс хэд хэдэн байгууллагын дунд ажил орхигдсон
НИЙТ ДҮН:			229,290,000		

Эрэгтэйчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах үйлчилгээ зэрэгт төсөв санхүүжилт тавигдсан бөгөөд төсөв санхүүжилтээсээ шалтгаалж, хэрэгжилт сайн хийгдсэн. Харин жендэрийн эрх тэгш байдал болон хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа шинжилгээг салбар бүрээр хийж олон нийтэд мэдээлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах, төрийн албан хаагчид болон жендэрийн мэргэжилтнийг чадавхжуулах шат дараалсан сургалт, арга хэмжээнд хамруулж, мэргэжил арга зүйгээр хангах, жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх ажлыг зохион байгуулах, олон нийтэд жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах мэдлэг олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулах чиглэлээрх ажлуудыг санхүүжүүлээгүй байна.

3.2.2 ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загвар нь хэр оновчтой байна вэ?

Баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загвар нь засч сайжруулах шаардлагатай нь харагдсан. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагаануудын шалгуур үзүүлэлтийн суурь түвшин байхгүй байгаа нь хяналт шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байлаа.

ОНЖДХ-ийн дэвшүүлсэн асуудал, зорилт, үйл ажиллагааны төлөвлөлтийн байдал нь уялдаа холбоотой боловч үйл ажиллагааны суурь түвшин, хүрэх түвшин тусгагдаагүй, хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан оноор нь тусгаагүй байгаа хэзээ ямар үйл ажиллагааг, ямар дарааллаар хэрэгжүүлэхийг тодорхойгүй болгож байна. Үйл ажиллагааг төлөвлөхдөө хугацааг 2018-2021 он гэж ерөнхийлөн заасан нь хэрэгжилт үр дүнг нарийн тооцож чадахгүй байх тал байгааг анхаарч сайжруулах шаардлагатай.

Мөн жил жилийн үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар, хэрэгжилтийн тайлагналтын загварт анхаарах шаардлагатай.

Аймгийн хэмжээнд Эрэгтэйчүүдийн анхдугаар чуулган, Халамжит аав гэсэн 2 томоохон арга хэмжээ 2019 онд зохион байгуулагдсаныг ОНЖДХ-ийн чиглэлийн хүрээнд төлөвлөгдөөгүйгээр хэрэгжсэн үйл ажиллагаанд хамааруулж үзлээ. Энэ үйл ажиллагаанууд нь ОНЖДХ-г зайлшгүй хамаарах шаардлагатай ажил байсан атлаа төлөвлөгдсөн үйл ажиллагаанд багтаагүй байв. Тиймээс цаашид ОНЖДХ-ийг төлөвлөхдөө зорилго, зорилтыг илүү өргөн хүрээнд тодорхойлох шаардлага байна гэж үзлээ.

3.2.3 ОНЖДХ-ийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт байна уу? Оновчтой эсэх?

ОНЖДХ нь үр нөлөөний 8 шалгуур тусгагдсан, үйл ажиллагаа бүрийн шалгуур үзүүлэлт тодорхой байгаа нь сайн талтай. Шалгуур үзүүлэлтүүдийн оновчтой байдал, салаа утгатай эсэх, асуудалд хамааралтай байдал, үр дүнг хэмжих үндэслэл болох, хяналт шинжилгээ хийх боломжтой эсэх зэргээр шинжилж үзээд шаардлага хангахуйц байна гэж дүгнэж үзлээ. Харин ОНЖДХ-ийг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, хүрэх түвшин тусгагдаагүй нь үнэлгээ хийхэд бэрхшээлтэй байсан.

Хүснэгт-9: Шалгуур үзүүлэлтийн байдал

Шалгуур үзүүлэлтийн төрөл	Тоо	Зөвлөмж
Орцын шалгуур үзүүлэлт	12 чиглэлийн үйл ажиллагаанд 229 сая 290 төгрөг зарцуулсан. Хэрэгжүүлэгч хүн хүч салбар хороо 10 салбар зөвлөл 105, ГБХЗХГ 25 ИНБ-ын сүлжээ 20 НТБТөв 35 нийт 195 хүн хүчний нөөцтэй	Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хүний болон санхүүгийн бодит нөөцөд тулгуурласан эх үүсвэр нь тодорхой байх Зарцуулсан санхүүжилтийг үнэлж дүгнэх боломжтой байх
Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт	төлөвлөсөн 34 үйл ажиллагаанд 34 шалгуур үзүүлэлт тогтоосон сургалт нөлөөлөл 14 удаа гэр бүл судлаач сэтгэл зүйч 20 хүн бэлтгэгдсэн гэх мэт үр дүнг хэмжих боломжтой байв	тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тэнцвэртэй ашиглах ЗДТГ болон салбар байгууллагуудын хяналт үнэлгээ мониторингийн тогтолцоонд нэгтгэн ашиглах боломжтой байх
Үйл явцын шалгуур үзүүлэлт	Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой гарсан тогтоол, захирамж тушаал 18 тайлан төлөвлөгөө 5 2020 оны тайланг аймгийн засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 19 хүн оролцож, 7 хүн саналаа хэлсэн.хамгаалах байр, эрэгтэйчүүдийн кабинет сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх 2 төв нээсэн гэх мэт	Үйл ажиллагаанд олон нийт, нийгмийн бүлгүү- дийн тэгш хүртээмжтэй оролцоог хангаж буй байдал хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой гарсан шийдвэрүүд тайлагналт зэрэг хэрэгжилтийн явцын ахиц дэвшлийн үзүүлэлт тодорхой байх
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Эрэгтэйчүүдийн кабинатаар 3900 хүн , түр хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвөөр 90 хүүхэд , 32 насанд хүрэгчид үйлчилүүлсэн .Сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх төв 2 байгуулагдаж 20 гэр бүл судлаач сэтгэл зүйчийг магисрт сурган төгсгөсөн Дээрхи кабинет, түр	Оролцогчдын цар хүрээ түншлэлийн чанарт гарч буй өөрчлөлтийг хэмжих боломжтой байх Орон нутагт төсвийн болон олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй уялдсан эсэх мэдээллийн эх сурвалж тодорхой байх

	хамгаалах байр, төвүүдийн орон тоо, төсөв санхүүг шийдвэрлэсэн .	
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт	ОНЖДХ –ийг хэрэгжүүлсэнээр гарах үр нөлөөний 8 шалгуур үзүүлэлт тусгагдсан ч суурь түвшин, зорилтот түвшин нь байхгүй.	ОНЖДХ хэрэгжсэнээр ямар өөрчлөлт үр дүн гарсаныг хэмжихийн тулд суурь болон зорилтот түвшинг тусгах

3.2.4 Хяналт шинжилгээний ямар дүгнэлт гаргасан байна вэ? Үр дүнд нь ямар өөрчлөлт гарсан бэ?

Аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны 05 сарын 07-ны өдрийн А/152 тоот тушаалаар “ОНЖДХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх тухай шийдвэр гарсан байна. Тус тушаалын дагуу орон нутгийн ИНБ-ууд ОНЖДХ-т хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллаж, 2020 оны 01 сарын 26-ны өдөр “Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн тайлан”-г гаргасан байна.

Уг тайланд ОНЖДХ-ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийсэн дүгнэлтэд дурдсанаас үзэхэд

- аймгийн жендэрийн салбар хорооноос сумдын салбар зөвлөлдөө зөвлөн туслах чиглүүлэх ажил хангалтгүй
- аймгийн салбар хорооны ажлын төлөвлөлт оновчтой биш
- хамтын ажиллагаа оролцоо дутмаг
- дотоод хяналт муу
- төсөв санхүү хангалтгүй
- олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөлөл хангалтгүй

гэсэн дүгнэлтүүдийг гаргаж, 7 заалт бүхий зөвлөмж боловсруулж, аймгийн жендэрийн салбар хорооны хуралд танилцуулсан.

ОНЖДХ-т 2019 онд хийгдсэн хяналт шинжилгээний үр дүнд:

- ОНЖДХ-ийн санхүүжилт нэмэгдэж, 2020, 2021 онуудад тус бүр 25 сая төгрөгөөр төсөвлөгдсөн
- Орон нутгийн ТББ-уудын оролцоо нэмэгдсэн.
- Аймгийн жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт хийгдэж, ИНБ-ын төлөөллүүдийг оруулсан зэрэг сайн талууд байгаа ч 2020 онд жендэрийн салбар хорооны ажил өмнөх жилүүдээс төдийлөн сайн идэвхжээгүй, сумдад салбар зөвлөл гүйцэт байгуулагдаагүй зэрэг анхаарууштай зүйлс байгаа болно.

Мөн ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд ямар хугацаанд, хэн хяналт шинжилгээ хийх, хяналт шинжилгээний төсвийг хэрхэн шийдэх талаар хөтөлбөрт заалт тусгагдаагүй байв.

3.2.5 Хэн оролцоод, хэн үр шим хүртсэн байна вэ?

ОНЖДХ-т хийсэн баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд жендэрийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд аймаг, сумдын төрийн албан хаагчид, ЕБС-ийн сурагчид, политехникийн коллежийн оюутнууд, цэцэрлэг, сургуулийн багш нар, цэргийн ангиудын алба хаагчид, уул уурхайтай сумдын залуучууд, ИНБ-ын ажиллагсад, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэд илүү оролцож үр шим хүртсэн байна.

ОНЖДХ-ийн 2019, 2020 оны тайлангаас үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг цуглуулж шинжлэн үзэхэд ихэнх тохиолдолд үйл ажиллагааны тайланд оролцогчдын тоо дурдсан боловч бүртгэл хөтөлгөө байхгүй, үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөр байхгүй, цаг хугацааг нарийн тэмдэглээгүй, оролцогчдын бүртгэлийн хөтөлгөөнд нас, хүйс, ажил зарим тохиолдолд тусгагдаагүй байлаа. Эндээс харахад ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл мэдээллийг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

ОНЖДХ-ийн 2019, 2020 оны сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэлийг доорх жагсаалтаар харууллаа.

Хүснэгт- 10: ОНЖДХ-ийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын бүртгэл

№	Зохион байгуулагдсан сургалт, нөлөөллийн ажлын нэр	Хамрагдсан хүний тоо	хүйсээр		Хэн хамрагдсан	Мэдээлэл байхгүй
			эр	эм		
1	Жендэрийн тухай ойлголт хүйсийн сэтгэл зүй	22	-	-	СӨБ-ийн багш ажилчид	Хүйсийн мэдээлэл байхгүй
2	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	33	17	16	ЗХ-ний 167-р анги	
3	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	54	28	--	Дулааны цахилгаан станц Захирагчийн албаны ажилчид	хүйсийн мэдээлэл дутуу
3	Миний биеийн аюулгүй дүрэм	21	10	11	1-р сургуулийн сурагчид	-
4	Уул уурхайн салбар дахь ЖЭТБ Байдал	42			Таван толгой ХК-ны ажилчид	Бүртгэл байхгүй
5	Жендэр ба хүний эрх	35	13	22	Төрийн албан хаагчид	
6	Жендэр ба хүний эрх чадавхижуулах сургалт	45	-	-	Сумдын засаг дарга Агентлагийн дарга мэргэжилтэн нар	Мэдээлэл дутуу
7	Уул уурхайн салбар дахь ЖЭТБ ба хөдөлмөр эрхлэлт	2100	-	-	Цогтцэций Ханбогд Гурвантэс сумдын залуучууд иргэд	Мэдээлэл дутуу
8	Хүүхдийн боловсролоос тусгаарагдаж буй шалтгаан бэрхшээл	55	26	29	Хүүхэд хамгаалалын ажилтан . багш эцэг эхийн төлөөлөл боловсролын удирдлага ИНБ-ууд	
9	Жендэрийн талаар ярилцъя сургалт хэлэлцүүлэг	20	-	20	Говийн ээжүүдийн хөгжлийн клуб	
10	Жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх	400			Политехникийн коллежи, багш нийгмийн ажилтан	мэдээлэл байхгүй

11	Жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах	350	350		15 сумдын төлөөлөл эрэгтэйчүүд	
12	Жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах	7600			Цэргийн ангиуд ЕБС, цэцэрлэг, ТББ коллежи	сургалт хийсэн 3 газарт
13	Жендэрийн үндсэн ойлголт ба хөдөлмөр эрхлэлт	60	14	46	Ханхонгор Даланзадгад Баяндалай сумдын иргэд	
14	Дундаж наслалт дахь жендэрийн зөрүү ба эрэгтэйчүүдийн эрүүл мэнд	58	58		Онцгой байдлын газар, цагдаагийн газар, Даланзалгад сумын ЗДТГ газар	
	Дүн:	10895				

Дээрх хүснэгт дэх ажлуудыг аймгийн ГБХЗХГазар, Насан туршийн боловсролын төв, Залуучуудын хөгжлийн төв зэрэг байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаж, тайландаа оролцсон хүний тоо, үйл ажиллагааг баримтжуулан аймгийн ЗДТГ-т ирүүлсэн байснаас мэдээллийг авав.

ОНЖДХ-ийн тайлангаас үзэхэд аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг түшиглэн байгуулсан эрэгтэйчүүдийн кабинетаар 2019 онд 3800 хүн, 2020 оны 10 сарын байдлаар 2928 хүн үйлчлүүлж эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээ авсан гэсэн тоон мэдээлэл байгаа боловч, бүртгэл мэдээлэл байхгүй байв.

ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн ажиллагсад, ажилгүй иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уул уурхайд ажиллагсад тэдний ар гэрийнхэн төдийлөн сайн оролцож чадахгүй орхигдож байна.

Эндээс харахад ОНЖДХ-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэхдээ төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийнхэн, ИНБ-хан гэх мэт нийгмийн идэвхтэй бүлгүүдэд түлхүү хүргэж, харин мэдээлэл дутмаг, алслагдсан болон нийгмийн идэвх сул иргэдэд хүргэх, тэднийг идэвхжүүлэх тал дээр төдийлөн сайн ажиллаж чадаагүй байна.

Төлөвлөгдөөгүй хэрэгжсэн үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, өрх толгойлсон иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж, 900 гаруй хүн хамрагджээ. Мөн эрэгтэйчүүдийн анхдугаар чуулганыг орон нутагт зохион байгуулж, 15 сумын 350 төлөөлөгчид оролцжээ. Харин уул уурхайд ажиллагсад, тэдгээрийн гэр бүл рүү хандсан ажил дутагдалтай байгааг анхаарах нь чухал.

Учир нь иргэдээс авсан асуулгын судалгаагаар орон нутагт жендэрийн эрх тэгш байдлын талаар бодлого хэрэгждэгийг “мэдэхгүй” гэсэн хариултыг хамгийн их буюу 41.2 хувь нь хариулж, ОНЖДХ-ийн хүрээнд хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны төсөл хөтөлбөрт хамрагдсан гэж судалгаанд оролцогчдын ердөө 5 хувь нь хариулсан бөгөөд хамрагдаагүй шалтгаанаа дурдахдаа 41.2 хувь нь мэдээ, мэдээлэл байдаггүй гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт-11: Асуулгын үр дүнгийн үзүүлэлт

Та манай аймагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого хэрэгждэгийг мэдэх үү?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Мэднэ	40	20.1	20.1	20.1
	Сонссон	70	35.2	35.2	55.3
	Зөвлөлдөх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд оролцож байсан	7	3.5	3.5	58.8
	Мэдэхгүй	82	41.2	41.2	100.0
	Total	199	100.0	100.0	

Хүснэгт-12: Асуулгын үр дүнгийн үзүүлэлт

Хэрэв та дээрх хөтөлбөрт хамрагдаагүй бол яагаад, шалтгааныг дурьдана уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Мэдлэг ойлголт, мэдээлэл байхгүй	82	41.2	41.2	41.2
	Оролцож байгаагүй, сонирхоогүй	57	28.6	28.6	69.8
	Ажил мэргэжлийн онцлогоос	20	10.1	10.1	79.9
	Түр оршин суугч учир	3	1.5	1.5	81.4
	Шалгуур өндөр	8	4.0	4.0	85.4
	Танил тал хардаг	11	5.5	5.5	91.0
	Хамрагдсан	10	5.0	5.0	96.0
	Боломж олдоогүй	4	2.0	2.0	98.0
	Насны хязгаар заасан	3	1.5	1.5	99.5
	Төсөл бичиж чадахгүй байна	1	.5	.5	100.0
	Total	199	100.0	100.0	

ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээнд судалгаанд оролцогчдын 56.3 хувь нь буюу 112 хүн “оролцож байгаагүй тул мэдэхгүй”, 21.1 хувь нь “тийм ч хангалттай биш”, 15.6 хувь нь “сайжруулах шаардлагатай”, 7 хувь нь “хангалттай” гэсэн хариултыг тус тус өгсөн. Эндээс 56.3 хувь буюу 112 хүн “ОНЖДХ-ийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаанд оролцож байгаагүй тул мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь цаашид ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарахыг бодлогын зөвлөмждөө тусгалаа.

Дүгнэлт:

ОНЖДХ-т хийсэн оролцооны хяналт шинжилгээ, оролцооны үнэлгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

ОНЖДХ-нь 4 зорилт 13 чиглэл 34 үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас 21 ажил буюу 61,8 % хэрэгжсэн, үүнээс гадна төлөвлөгдөөгүй 5 ажил хийгдсэн байна. ОНЖДХ-ийн хүрээнд төлөвлөгдөөд хэрэгжсэн үйл ажиллагаанаас хохирогчдыг хамгаалах байр, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд, эрэгтэйчүүдийн кабинет

байгуулагдаж, хүний нөөцийн орон тоог бий болгож ажиллуулсан зэрэг ажлууд нилээд үр дүнтэй, цаашид орон нутагт хэрэгтэй ажил болсон байлаа. Мөн энд онцлон дурдахад эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулж, эрэгтэйчүүдийн эмчийг сургалтанд хамруулж мэргэшүүлсэн нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ, зөвлөгөө нэмэгдсэн сайн ажил болсон байна.

ОНЖДХ-т төлөвлөгдөөгүйгээр хийгдсэн үйл ажиллагаанд ХХҮГ-аас хэрэгжүүлсэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагаа, ГБХЗХГ-аас зохион байгуулсан эрэгтэйчүүдийн чуулган болон аавуудад чиглэсэн үйл ажиллагаа, гэрлэх ёслолыг орон нутагт зохион байгуулдаг болсон зэрэг үр дүнтэй ажлууд хийгдсэн байна.

Оролцооны үнэлгээний үр дүнд орон нутгийн иргэдээс авсан асуулгаас үзэхэд ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжийн үнэлгээнд судалгаанд оролцогчдын 56.3 хувь нь “ОНЖДХ-ийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаанд оролцож байгаагүй тул мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь цаашид ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн бүлэг, цаашлаад хүн бүрт хүргэхэд онцгой анхаарах хэрэгтэйг харууллаа.

ОНЖДХ-өөс төлөвлөгдсөн хэрнээ орхигдсон ажлууд нь уул уурхайтай хамтран ажиллах, уул уурхайд ажиллагсдын гэр бүл рүү хандсан бодлого үйл ажиллагаа хийх, олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хувийн хэвшлийнхэн, ажилгүй иргэд, малчид, уул уурхайн салбарын ажиллагсад зохион байгуулах, хүйсээр ангилсан мэдээлэл судалгаа хийх, сургагч багш бэлтгэх зэрэг ажлууд төлөвлөсөн түвшинд хийгдээгүйг дурдсан бөгөөд хэрэгжээгүй орхигдсон шалтгаан нь Ковид19-тэй холбоотой хөл хорио, аймгийн салбар хороо цөөн хуралдсан, тодорхой шийдвэр гаргах, хяналт тавих талаар хангалтгүй ажилласан, салбар зөвлөлүүд төсөвгүй, жигд ажиллаагүй зэрэг шалтгаанаас болсныг тодорхойлсон.

ОНЖДХ-т хийсэн баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд жендэрийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд аймаг сумдын ЗДТГ-ын төрийн албан хаагчид, Политехникийн коллежийн оюутнууд, цэцэрлэг, сургуулийн багш нар, цэргийн ангийн албан хаагчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажиллагсад, ИНБ-ын ажиллагсад, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэд илүү оролцож, үр шим хүртсэн байна.

Харин ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн ажиллагсад, ажилгүй иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уул уурхайд ажиллагсад тэдний ар гэрийнхэн төдийлөн сайн оролцож чадахгүй орхигдсон байна.

Эндээс харахад ОНЖДХ-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэхдээ төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийнхэн, ИНБ-хан гэх мэт нийгмийн идэвхтэй бүлгүүдэд түлхүү хүргэж, харин мэдээлэл дутмаг, алслагдсан болон нийгмийн идэвх сул иргэдэд хүргэх, тэднийг идэвхжүүлэх тал дээр төдийлөн сайн ажиллаж чадаагүй байна гэж дүгнэлээ.

Энэхүү дүгнэлтүүдэд үндэслэн ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой болгох, төсөв санхүүг нэмэгдүүлэх, орон нутгийн жендэрийн салбар хороог идэвхжүүлэх, орхигдсон бүлгүүдэд үйл ажиллагааг чиглүүлэх талаар бодлогын зөвлөмж боловсруулж ажиллалаа.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ:

ОНЖДХ-т хийсэн оролцооны хяналт шинжилгээ, оролцооны үнэлгээнд үндэслэн ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулах, арга хэмжээний төлөвлөлтийг оновчтой болгох, төсөв санхүүг нэмэгдүүлэх, орон нутгийн жендэрийн салбар хороог идэвхжүүлэх, орхигдсон бүлгүүдэд үйл ажиллагааг чиглүүлэх талаар дараах бодлогын зөвлөмжийг боловсрууллаа.

1. ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулж, үйл ажиллагаа бүрт хүрэх түвшин, суурь түвшинг тодорхой болгож, шалгуур үзүүлэлтүүдэд анхаарах
2. ОНЖДХ-ийн үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой болгож, орхигдсон зорилтот бүлгүүд болох хувийн хэвшлийнхэн, ажилгүй иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уул уурхайд ажиллагсад, тэдгээрийн гэр бүл рүү илүү чиглүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, хяналт үнэлгээг хийх ажлыг санхүүжилттэйгээр төлөвлөлтөд тусгах
3. Аймгийн жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулан идэвхжүүлж, гишүүдийг тодорхой ажил үүргийн хуваарьтай болгон хариуцлага, хамтын ажиллагааг сайжруулах
4. Сумдад жендэрийн дэд салбар хороодыг бүрэн байгуулж, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулж, ажлын тайланг сонсож дүгнэдэг болох
5. ОНЖДХ-ийн төсөв санхүүг жилээс жилд нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх, аймгийн салбар хороо, сумдын салбар зөвлөлийг санхүүжилттэй болгох
6. Жендэрийн асуудал хариуцсан хүний нөөцийг орон тоогоор ажиллуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавих, салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах боломжийг бүрдүүлэх
7. Иргэд, олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр жендэрийн сургагч багш нарыг аймгийн хэмжээнд сум бүрт бэлтгэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, хяналт тавих
8. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулах чиглэлээр орон нутгийн удирдлагууд, байгууллагын дарга, эрхлэгчид, хүний нөөцийн мэргэжилтэнүүдийг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах
9. ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээ мэдээллээр хангахад хэвлэл мэдээллийн байгууллагыг бодлогоор татан оролцуулах
10. Жендэрийн эрх тэгш байдал болон хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа шинжилгээг салбар бүрээр хийж, бодлого төлөвлөлтөнд ашиглах, олон нийтэд мэдээлдэг байх

Хүснэгт-13: Дүгнэлт, бодлогын зөвлөмж

	ОХШҮ-ний үр дүн	Дүгнэлт	Зөвлөмж
1	ОНЖДХ-ийн төлөвлөлт уялдаа холбоотой боловч үйл ажиллагааны суурь түвшин, хүрэх түвшин тусгагдаагүй, хугацааг оноор нь тусгаагүй зэргээс шалтгаалж цаашид засч сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Мөн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар, хэрэгжилтийн	ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой болгох шаардлагатай.	ОНЖДХ-ийн төлөвлөлтийн загварыг сайжруулж, үйл ажиллагаа бүрт хүрэх түвшин, суурь түвшинг тодорхой болгож, шалгуур үзүүлэлтүүдэд анхаарах ОНЖДХ-ийн үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой болгож, орхигдсон зорилтот бүлгүүд болох хувийн

	тайлагналтын загварт анхаарах шаардлагатай.		хэвшлийнхэн, ажилгүй иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уул уурхайд ажиллагсад, тэдгээрийн гэр бүл рүү илүү чиглүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, хяналт үнэлгээг хийх ажлыг санхүүжилттэйгээр төлөвлөлтөд тусгах
2	<p>Аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны 05 сарын 07-ны өдрийн А/152 тоот тушаалаар “ОНЖДХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх тухай шийдвэрийн дагуу орон нутгийн ИНБ-ууд ОНЖДХ-т хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2020 оны 01 сарын 26-ны өдөр “Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн тайлан”-г гаргасан байна. Уг тайланд ОНЖДХ-ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийсэн дүгнэлтэд дурдсанаас үзэхэд</p> <ul style="list-style-type: none"> - аймгийн жендэрийн салбар хорооноос сумдын салбар зөвлөлдөө зөвлөн туслах чиглүүлэх ажил хангалтгүй - аймгийн салбар хорооны ажлын төлөвлөлт оновчтой биш - хамтын ажиллагаа оролцоо дутмаг - дотоод хяналт муу - төсөв санхүү хангалтгүй - олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөлөл хангалтгүй <p>гэсэн дүгнэлтүүдийг тусгасан байна.</p>	Аймгийн 15 сумын 7 суманд жендэрийн салбар зөвлөл байгуулагдаж, 8 суманд байгуулагдаагүй байгаа нь орон нутагт жендэрийн салбар хороо, салбар зөвлөлийн ажил хангалттай хэмжээнд ажиллаж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна.	<p>Аймгийн жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулан идэвхжүүлж, гишүүдийг тодорхой ажил үүргийн хуваарьтай болгон хариуцлага, хамтын ажиллагааг сайжруулах</p> <p>Сумдад жендэрийн дэд салбар хороодыг бүрэн байгуулж, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг төлөвлөгөөнд тусган үе шаттай зохион байгуулах, салбар зөвлөлийн жилийн ажлын тайланг дүгнэхэд анхаарах</p>
3	ОНЖДХ-ийн төсвийн төлөвлөлтийн талаар баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд ОНЖДХ нь 2018 онд батлагдаж, 2019 онд 2.0 сая, 2019, 2020 онуудад тус бүр 25.0 сая төгрөг батлагдсан нь төсвийн хувьд мөнгө, санхүүг төлөвлөх байдалд анхаарч байгаа нь харагдсан боловч хөтөлбөрийн үйл ажиллагааг орон нутгийн нийт	ОНЖДХ-ийн төсөв 2019 онд 2.0 сая, 2019, 2020 онуудад тус бүр 25.0 сая төгрөг батлагдсан нь төсвийн хувьд мөнгө, санхүүг төлөвлөх байдалд анхаарч байгаа нь харагдсан боловч хөтөлбөрийн үйл ажиллагааг орон	ОНЖДХ-ийн төсөв санхүүг жилээс жилд нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх, аймгийн салбар хороо, сумдын салбар зөвлөлийг санхүүжилттэй болгох

	иргэдэд хүртээмжтэй хүргэх, жендэрийн салбар хороо, зөвлөлүүдийг төсөвтэй болгоход анхаарах шаардлагатай гэж үзэж байна.	нутгийн нийт иргэдэд хүртээмжтэй хүргэх, жендэрийн салбар хороо, зөвлөлүүдийг төсөвтэй болгоход анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.	
4	ОХУ-ний явцад орон нутгийн шийдвэр гаргагчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар жендэрийн хүний нөөцийг бэлтгэхэд анхаарах, нэмэгдүүлэх, мэргэжилтэнг орон тоогоор ажиллуулах шаардлагатай байгааг гарган тавьсан.	Аймгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн орон тоогоор ажилладаггүй, давхар олон ажил, хөтөлбөр хариуцдаг нь жендэрийн бодлого хэрэгжилтийг хангах, салбар хороо, зөвлөлүүдийн ажлыг идэвхжүүлэх, уялдаа холбоог хангахад сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэв.	Жендэрийн асуудал хариуцсан хүний нөөцийг орон тоогоор ажиллуулах шаардлагатай. Ингэснээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавих, салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах боломжийг бүрдүүлэх юм.
5	ОХШҮ-нээс харахад жендэрийн сургалт зохион байгуулах сургагч багш бэлтгэх ажлыг төлөвлөсөн ч хийгдээгүй байна. Шийдвэр гаргах түвшнийхэнд жендэрийн сургалт үйл ажиллагаа зохион байгуулсан боловч албан байгууллагын дарга нар хамрагдаагүй, төлөөний хүмүүсээ хамруулсан байна.	Цаашид иргэд, олон нийтийн жендэрийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд сургагч багш бэлтгэж, ажиллах нөхцлийг нь бүрдүүлэх хэрэгтэй гэж үзлээ. Мөн шийдвэр гаргагчид, албан байгууллагын дарга нарт жендэрийн сургалтыг зохион байгуулах шаардлага байна гэж дүгнэж байна.	Мөн жендэрийн чиглэлээр хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байгаа бөгөөд иргэд, олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр жендэрийн сургагч багш нарыг аймгийн хэмжээнд сум бүрт бэлтгэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, хяналт тавих, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулах чиглэлээр орон нутгийн удирдлагууд, байгууллагын дарга, эрхлэгчид, хүний нөөцийн мэргэжилтэнүүдийг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах
6	ОХШҮ-ний явцад ОНЖДХ-ийн хүрээнд сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж, 11200 хүнийг хамруулсан байгаа боловч иргэдээс авсан асуулгын судалгаагаар жендэрийн бодлого, хөтөлбөрийг мэдэхгүй, үйл ажиллагаанд нь оролцоогүй тул мэдэхгүй, мэдлэг ойлголт хангалтгүй байна гэсэн хариултауд 41.2-56.3 хувьтай гарч ирсэн.	Эндээс дүгнэж үзэхэд ОНЖДХ-ийн үйл ажиллагааг сурталчлах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах чиглэлийн мэдээлэл сурталчилгааны ажил дутагдалтай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.	ОНЖДХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээ мэдээллээр хангахад хэвлэл мэдээллийн байгууллагыг бодлогоор татан оролцуулах

7	ОХШҮ-гээр ОНЖДХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг Хөдөө аж ахуйн салбар, уул уурхай зэрэг салбар, салбаруудад хийхээр тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байлаа.	Жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр салбар бүрт шаардлагатай судалгаануудыг хийх шаардлага байна гэж дүгнэв.	Жендэрийн эрх тэгш байдал болон хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа шинжилгээг салбар бүрээр хийж, бодлого төлөвлөлтөнд ашиглах, олон нийтэд мэдээлдэг байх
---	---	---	---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын гарын авлага 2020 он.УБ
2. Иргэдээс авсан асуулгын судалгааны удирдамж, үр дүн
3. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын удирдамж, үр дүн
4. ОНЖДХ-ийн баримт бичгүүд / баримт бичгийн жагсаалтыг хавсралтад оруулсан болно /
5. Зөвлөлдөх уулзалтын санал, дүгнэлт

ХАВСРАЛТ:

1. Баримт бичгийн жагсаалт:
2. ОХШ-ний маягт / хавсралтаар илгээв /
3. Асуулгын удирдамж
4. Ганцаарчилсан ярилцлагын удирдамж, дүгнэлт
5. Бүлгийн ярилцлагын удирдамж, дүгнэлт